

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

“ХХIII.3. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2015 оны жилийн эцсийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав.


Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.

1. Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу, шуурхай зохион байгуулах;

2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитойгоор хяналт-шинжилгээ хийж үнэлэн тайлагнах;

3. 2015 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д бүртгүүлж, хяналтаас хасуулах;

4. Хуульд заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР